



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 29 дүгээр зүйлийн 29.1.10 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11-т заасныг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ:

1. Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг СЕХ-ноос ирүүлсэн аргачлал, зөвлөмж, чиглэлийн дагуу хуваарилсан байна.
2. Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
3. Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь сонгуульд ажилласан албан хаагч нарт олгосон урамшуулал, хоолны зардалд татварын е-баримтгүй гүйлгээ хийсэн байна.
4. Аймгийн Сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.
5. Шилэн дансны цахим сайтад Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь 13.2 сая төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Тайланг хүргүүлсэн этгээд: Дорнод аймгийн Сонгуулийн хороо болон Үндэсний аудитын газар

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер И.Сэмжидмаа Утас: 7058-4207,
Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Батжаргал Утас: 7058-4207,
Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг Утас: 7058-4207,
Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn ganbilegm@audit.gov.mn

Чойбалсан хот 2023 он

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ: Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Чойбалсан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх

Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон Чойбалсан сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг хамрууллаа.

Аудитын гол үр дүн:

- **БҮЛЭГ 1. ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ СЕХ-НООС ИРҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, ЗӨВЛӨМЖ, ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА.**

- Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны даргын 2023 оны А/19 дугаартай тушаалаар Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны төсвийг 34.3 сая төгрөгөөр баталсан байна.

- Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн хуваарилсан байна.

- Дорнод аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах сумын Сонгуулийн хорооны санхүүжилтийг олгохдоо Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2023 оны 3/172, 3/217, 3/236, 3/240 тоот албан бичгээр ирүүлсэн зарцуулалтын тайлбар, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2022 оны А/17 дугаар захирамжийн дагуу төсвийг зардал тус бүрээр суманд хуваарилан олгосон байна.

• БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

- Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуулийн зардалд улсын төсвөөс хуваарилсан 34.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна.
- Дорнод Аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч цахим төлбөрийн мэдэгдэл гаргаж нэг удаагийн нууц дугаарууд ашиглан цахимаар гүйлгээг хийж ажилласан байна.
- Харин Чойбалсан сумын Сонгуулийн хорооны дарга сонгуулийн хорооны зардлын нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг зурж ажилласан байна.
- Аймгийн сонгуулийн хороо 16.3 сая төгрөг, Чойбалсан сумын сонгуулийн хороо 17.0 сая төгрөг, нийт 33.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс аймгийн Сонгуулийн хороо болзошгүй зардалд тавигдсан 1.0 сая төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлжээ.

• БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНАСАН БАЙНА.

- Дорнод аймгийн Чойбалсан сумын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аймгийн Сонгуулийн хороо 16.3 сая төгрөг, Чойбалсан сумын сонгуулийн хороо 17.0 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан байна.
- Аймгийн Сонгуулийн хороо нь Чойбалсан сумын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.
- Аудитаар аймгийн болон Чойбалсан сумын Сонгуулийн хорооны 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг тулган үзэхэд 5.0 сая төгрөгөөс дээш 13.2 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээг байршуулж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг СЕХ-ноос ирүүлсэн аргачлал, зөвлөмж, чиглэлийн дагуу хуваарилсан байна.
2. Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулсан зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
3. Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь сонгуульд ажилласан албан хаагч нарт олгосон урамшуулал, хоолны зардалд татварын е-баримтгүй гүйлгээ хийсэн байна.
4. Аймгийн Сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, гүйцэтгэлд аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч хяналтыг тавьж ажилласан байна.
5. Шилэн дансны цахим сайтад Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь 13.2 сая төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.

Аудитаар нийт 16.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 1.6 сая төгрөгийн албан шаардлага, 14.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллаа.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч байна.

1. Чойбалсан сумын Сонгуулийн хороо нь сонгуульд ажилласан албан хаагч нарт олгосон урамшуулал, хоолны зардалд татварын е-баримтаар шилжүүлэг хийж байх.
2. Шилэн дансны тухай хуульд заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлж байх.

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.